

ТАНИЛЦУУЛГА

Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмын төслийн тухай

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ыг нийгмийн хамгааллын, хууль зүйн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/281, А/380 дугаар хамтарсан тушаалаар “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам” батлагдан хэрэгжиж байна.

Хүчирхийллийн хохирогч түүний гэр бүлийн гишүүнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын үйлчилгээг анхан шатанд үзүүлэх чиг үүрэг бүхий салбар дундын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл болох Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 676 Хамтарсан багын гишүүдийн чиг үүрэг, ажиллах зарчим болон хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүл, хүчирхийллийн хохирогч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хамгааллын болон урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлэхэд зөвшөөрөгдөх зардлын төрөл, хэмжээг тооцох үйлчилгээний жишиг зардлыг тооцож, Хамтарсан багийн үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээний асуудлыг шинээр тусгаад байна.

Энэхүү журмын төслийн хавсралтаар Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний “Жишиг зардлыг тооцох аргачлал”, “Хяналт шинжилгээ, үнэлгээний маягт” болон “Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний маягт”, “Хамтарсан багаас үзүүлсэн үйлчилгээг хянах хяналтын хуудас”-ыг мөн боловсрууллаа.

Энэхүү шинэчилсэн журмын төсөл батлагдсанаар гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, охид, эмэгтэйчүүдийг хамгаалах чиглэлээр анхан шатанд ажилладаг Хамтарсан багаас үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна гэж үзэж байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ